

The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

2022 ОНЫ 9-Р САР

МОНГОЛ УЛСЫН ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Зохиогчийн эрх © Энэхүү бодлогын баримт бичгийг Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам)-ын Худалдаа, Хөрөнгө оруулалтын хороо боловсруулсан болно.

Бодлогын баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд АмЧам-аас зөвшөөрөл авна.

2022 оны 9-р сар
Улаанбаатар хот



МОНГОЛ ДАХЬ АМЕРИКИЙН ХУДАЛДААНЫ ТАНХИМ ХУДАЛДАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХОРОО

Ерөнхий тойм

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим “Монгол улсын худалдаа, хөрөнгө оруулалтын бодлого” гэсэн энэхүү бодлогын баримт бичигт Монгол улсын Засгийн газраас гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО)-ыг татах, хамгаалах чиглэлээр явуулж байсан болон явуулж буй бодлогын арга хэмжээнүүд, тухайлбал “Алсын Хараа 2050” болон Шинэ сэргэлтийн бодлогыг тоймлон, цаашдаа гуравдагч хөршийн хөгжингүй орнуудаас ГШХО татах тал дээр онцгой анхаарал тавих шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн болно.

Түүнчлэн энэхүү баримт бичигт худалдаа, хөрөнгө оруулалтанд нөлөөлж буй хүчин зүйлүүд болон Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын зүгээс хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийг дэмжихийн тулд худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг хэрхэн сайжруулах шаардлагатай байгаа талаар АмЧам Монголын бодлогын шинэчлэлийн 3 тулгуур бүхий зөвлөмжүүдийг тусгасан болно. Үүнд:

1. Хувийн хэвшлийн бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид манлайлсан чөлөөт зах зээлийн эдийн засгийг тууштай дэмжин хөгжүүлэх;
2. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг шинэчлэх;
3. АНУ болон гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүс нутгийн худалдааны интеграцыг нэн тэргүүнд тавих.



Оршил

Хоёр их гүрний дунд оршдог Монгол Улс хөрөнгө оруулагчдад геополитикийн өвөрмөц байршлыг бүрдүүлж байна. Монгол Улс олон улсын хамгийн том зах зээл болох БНХАУ болон олон улсын бизнесийн нийгэмлэгийн эдийн засгийн хориг арга хэмжээнд өртөөд буй ОХУ-тай хил залгадаг.

Хоёр хөршийн нөхцөл байдал туйлын хүнд байгаа нь Монгол Улсын худалдааны эргэлтэд шууд нөлөөлдөг. Тухайлбал, Ковид-19 цар тахлын улмаас БНХАУ-ын хилийн хорио, хязгаарлалт үргэлжилсээр байна. ОХУ хөрш орныхоо эсрэг дайсагнаж, цэрэг, дайны үйл ажиллагаа явуулж байгаа нь дэлхийн болон манай улсын эдийн засгийн өсөлтийг сааруулж, хүнсний болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүний хомсдол, үнийн өсөлт, инфляц г.м. олон бэрхшээлүүдийг үүсгээд байна.

Иймд Монгол Улс бусад орны хөрөнгө оруулалтыг татаж, авч үлдэхийн тулд “гуравдагч хөрш”-ийн бодлогыг эрчимтэй явуулах нь нэн чухал. Хөрш орнуудаас хэт хараат байдлаас гарах гарц нь гуравдагч хөрш болон хөгжингүй орнуудын ГШХО-ыг нэмэгдүүлэх явдал гэж Монгол дахь Америкийн Худалдааны Танхим үзэж байна.

Агуулга

1.1. Монгол Улсын гуравдагч хөршийн бодлогын үндэс

2010 онд УИХ-аас Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн баталсан бөгөөд үүнд “Монгол Улс олон тулгуурт эдийн засгийн бодлого, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого, санхүү, эрчим хүч, уул уурхай, гадаад худалдааны салбарын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн ухаалаг бодлого хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг. Цаашлаад Монгол Улс стратегийн салбаруудад нэг улсаас орж ирэх ГШХО-ын хэмжээг Монгол Улсад орж ирж буй ГШХО-ын гуравны нэгээс илүүгүй байлгах, гадаадын төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтыг хязгаарлах, хөрш орнууд болон өндөр хөгжилтэй орнуудын хөрөнгө оруулалтын тэнцвэрийг хадгалах зорилт тавин ажиллаж байна.

2011 оны 2 дугаар сарын 10-нд энэхүү үзэл баримтлалд нэмэлт өөрчлөлт оруулж, “Гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” гэж тодорхой заасан байдаг.¹

¹ Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлал, 3.1.1.5-р заалт, 2010.



1.2 Алсын хараа 2050

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн баримт бичиг болох “Алсын хараа 2050”-д хөрөнгө оруулалтыг дэмжих талаар хэд хэдэн заалтууд тусгасан байдаг. Үүнд:

- “4.1.6. Ил тод байдал, хамтын ажиллагаанд тулгуурлан гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид хоорондын хамтын ажиллагаа, холболтын сувгийг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ”²;
- “4.1.30. Хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх чиглэлээр:
- 4.1.31. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлж, ханган нийлүүлэлтийг хөгжүүлэх үндэсний бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.1.32. Гадаадын хөрөнгө оруулалтын эрэлт хэрэгцээг салбараар, байршлаар тодорхойлон, байршил, салбар бүрийн онцлогоос хамааран хөрөнгө оруулалтыг татах бодлогыг шинэчлэн боловсруулна.
- 4.1.33. Гадаадын хөрөнгө оруулалтыг дотоодын ААН-үүдтэй холбох холбоосыг бий болгох зорилгоор сургалт хийх, шинэчлэн зохион байгуулах, улмаар хамтран ажиллах орчинг сайжруулна.
- 4.1.34. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын санаачилгыг дэмжих тухай хууль боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.1.35. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлогыг олон улсын жишигт хүргэн шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.”³

1.3. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газар 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө бизнесийн таатай орчин, ГШХО татах талаар дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- “4.4.6 Хувийн өмч, хөрөнгө оруулалт, оюуны өмчийн эрхийг хамгаалах, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, цахим гэрээ, хэлцлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, цахим орчинд хийсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримт болгон авч үзэх, шүүхийн зарим үйл ажиллагааг цахимжуулах; Баялаг бүтээгчид, хувийн хэвшлийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 4.5.3 Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, хөнгөлөлттэй зээл, тусламж авахад дэмжлэг үзүүлнэ.”⁴

1.4 Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал 2019-2023

2019 онд Монгол Улсын Худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглалыг Гадаад харилцааны яам, МҮХАҮТ-аас Олон улсын худалдааны төвийн

² Алсын Хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 201-р хуудас

³ Алсын Хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, 205-р хуудас

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 15-16-р хуудас



дэмжлэгтэйгээр боловсруулсан. Худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглалын ерөнхий зорилго нь Өв соёл, бүтээлч байдлаа ашиглан худалдаа, хөрөнгө оруулалтад тулгуурласан өсөлтийг дэмжих эрч хүчтэй Монгол Улсыг дараах 4 стратегийн зорилтоор хангана. Үүнд:

1. “Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх замаар урт хугацааны өсөлтийн замыг бий болгох;
2. Монголын компаниудын хэрэгцээнд үр дүнтэй хариу өгөхийн тулд худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих байгууллагуудыг бэхжүүлэх;
3. Зах зээлийн шаардлагыг хангах, экспортын харилцааг тогтвортой байлгахын тулд компаниудын чадавхийг нэмэгдүүлэх;
4. Бизнес эрхлэх чадавхийг нээж, гарааны бизнесийн эко системийг бэхжүүлж, мэдлэгт суурилсан салбар руу тэмүүлэх замаар инноваци, гарааны бизнесүүдийг идэвхжүүлнэ”⁵.

1.5 Монгол улсын Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлого

Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, Ковид-19 цар тахлын эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийн саад хүндрэлийг нэн даруй шийдвэрлэх, Алсын Хараа 2050-г хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн “Шинэ сэргэлтийн бодлогыг” 2021 онд Засгийн газраас санаачилсан.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөнө.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод дэвшүүлсэн эхний үе шатны зорилго, зорилт хангагдах суурь нөхцөл бүрдэнэ.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд төр-хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын идэвхтэй түншлэлд тулгуурлан Монгол Улсын хөгжлийг хязгаарлаж буй зургаан багц асуудлыг шийдвэрлэх болно. Үүнд: боомт, төрийн бүтээмж, байгал хөгжил, эрчим хүч, аж үйлдвэр, хот хөдөөгийн хөгжил гэсэн үндсэн зургаан чиглэлээр хэрэгжиж байна.

Засгийн газар хувийн хэвшилтэй хамтран төмөр зам, хилийн боомт, Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлыг сайжруулах зэрэг 94 төсөл хэрэгжүүлж, цахилгаан станцууд, газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэт, Таван толгой, Оюутолгойн ордуудыг өргөтгөх, гацааг арилгах, эдгээр салбарт ГШХО-ыг илүү татах зорилгоор төрийн үйлчилгээг цахимжуулна.

Энэхүү Шинэ сэргэлтийн бодлогын Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд Засгийн газраас дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

“3.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник,

⁵ Монгол Улсын худалдаа, хөрөнгө оруулалтын замын зураглал 2019-2023, 23-25-р хуудас:



технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна.

3.2. Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлнэ.

3.3. Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.

3.4. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацад тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ болон үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

3.5. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

3.6. Шинжлэх ухаанд суурилсан өндөр технологи, блокчейн, хиймэл оюун ухааны ололтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.”⁶

2. Олон улсын туршлага, улс орны нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ

Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын худалдааны бодлогын тойм

ДХБ-ын Худалдааны бодлогын тоймд дурдсанаар Монгол Улсын өнөөгийн Засгийн газар гадаад худалдаа, эдийн засгийн гадаад хамтын ажиллагаанд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- “Экспортын санхүүжилт, экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх шийдэл боловсруулах;
- Гадаад худалдааг дэмжих, урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор гаалийн үйлчилгээг хялбаршуулан иргэдийг хууль бус, хуурамч бүтээгдэхүүнээс хамгаалах, гаалийн шинэчлэлийг бүрэн гүйцэд үргэлжлүүлэх байгалийн баялгийн ашиглалтаас татвар, нөөц ашигласны төлбөр авах; чөлөөт худалдааны дэд бүтцийг бий болгох, хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлнэ бүс, худалдаа, үйлчилгээ, хөнгөн хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх экспортын болон дотоодын зах зээлд чиглэсэн, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг татах;
- Зах зээл, байгалийн баялагт ойр, ажиллах хүч, аж үйлдвэр хөгжих боломж бүхий сонгогдсон бүс нутгуудад эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүдийг хилийн боомттой зэрэгцүүлэн байгуулах;
- Бүтээгдэхүүнээ экспортолж буй аж ахуйн нэгжүүдэд тодорхой дэмжлэг үзүүлэх зорилгоор “Экспортын баталгааны сан” байгуулах;

⁶ Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО, 1-р хуудас



- Хилийн боомтуудын нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, хөрш орнуудын боомтын жишигт нийцүүлэх; хилийн боомтуудын барилга байгууламжийг шинэчлэх, чанарыг сайжруулах;
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотооддоо бүрэн хангах, импортыг орлох болон экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх;
- ОХУ-аас Монгол Улсаар дамжин Хятад руу байгалийн хий дамжуулах хоолойн ТЭЗҮ-ийг хийж дуусгаж, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах;
- Эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор зам, тээврийн сүлжээг өргөтгөх;
- Гадаад эдийн засгийн харилцаанд нэн тэргүүнд анхаарч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд учирч буй хүндрэлийг багасгах, бууруулах бодлогыг үргэлжлүүлэх;
- Дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон холбогдох мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хөнгөлөлттэй зээл, тусламж авахыг дэмжинэ.”⁷

2.2. Худалдаа, хөрөнгө оруулалтад нөлөөлж буй хүчин зүйлүүд

Дэлхийн банкны “Тогтвортой бус цаг үед хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх нь” тайланд дурдсанаар, КОВИД-19 цар тахлын дэгдэлт гарахаас өмнө ч дэлхийн ГШХО нь худалдааны бодлогын тодорхойгүй байдал, газар авч буй протекционизм, ГШХО-ын өгөөжийн түвшин буурсан, үйлдвэрлэл, олон улсын хөрөнгө оруулалтын хэлбэр өөрчлөгдсөн зэргээс шалтгаалан буурч байсан.

КОВИД-19 цар тахал нь хөрөнгө оруулагчдын итгэлийг түүхэн доод хэмжээнд хүртэл бууруулж, 2020 онд дэлхийн ГШХО-ыг 40 гаруй хувиар бууруулж буй хөрөнгө оруулагчдын эрсдэлийн шинэ, урьд өмнө байгаагүй эх үүсвэрийг бий болгож байна.

Хөгжиж буй орнуудын үндэстэн дамнасан хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос илүү нь КОВИД-19 цар тахлын улмаас нийлүүлэлтийн сүлжээ тасалдаж, орлого буурч, үйлдвэрлэл буурсан тухай мэдээлж байгаа ба цар тахлын нөлөөллийн талаарх Дэлхийн банкны шинэ судалгаанд үндэслэн ирэх саруудад нөлөө нь улам дордох төлөвтэй гэв.

ГШХО нь улсын өрийг санхүүжүүлэхийн тулд гадаад хөрөнгийн чухал эх үүсвэрээр хангаж, илүү олон, илүү сайн цалинтай ажлын байр бий болгож, хүмүүсийг ядуурлаас ангижруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар КОВИД-19 -ийн хямралын нөлөөллийг бууруулж, улс орнуудын эдийн засгийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

Энэхүү тайлангийн дагуу хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулахдаа янз бүрийн хүчин зүйлийг харгалзан үздэг. Хамгийн чухал хоёр хүчин зүйл нь:

⁷ Дэлхийн Худалдааны Байгууллагын худалдааны бодлогын тойм, 2021, Ерөнхий тойм.



- Улс төрийн тогтвортой байдал, аюулгүй байдал
- Бизнес ээлтэй хууль эрхзүйн орчин.

Хууль эрхзүйн орчны тодорхойгүй болон үр ашигтай байдлыг бизнесийн орчны чухал элементүүд гэж үздэг.

Хөрөнгө оруулалт татахын тулд засгийн газрууд улс төрийн эрсдэлийг бууруулж, хамгаалалт, тогтвортой байдал, урьдчилан таамаглах боломжтой байдлыг нэмэгдүүлэх ёстой.


Хөрөнгө оруулагчдын 90 хувь нь хууль эрх зүйн тогтвортой байдал нь чухал өндөр ач холбогдолтой гэж үздэг, тухайлбал:

- Дотоод болон гадагшаа валют шилжүүлэх боломжтой байх;
- Хувийн өмчийг нийгэмчлэх, гэрээгээ зөрчих, төрийн ил тод бус, дур зоргоороо авирлахаас хамгаалсан эрх зүйн хамгаалалт.

Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагууд ГШХО-ыг татах, хадгалах хүчин чармайлтаа зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулж, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татсанаар улс орныхоо хөрөнгө оруулалтын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжтой.

Засгийн газрууд протекционист бодлогоос зайлсхийж, ГШХО болон нийлүүлэлтийн гинжин хэлхээний чиг хандлагыг өөрчлөх шинэ боломжуудыг ашиглах, дэлхийн хамтын ажиллагааг дэмжих замаар КОВИД-19 цар тахлаас эдийн засгийн сэргэлтэнд шилжихдээ ГШХО-ыг ашиглах боломжтой.

Figure 7. Factors influencing trade costs of Asia-Pacific economies



Зураг 7-д хууль эрхзүйн таатай орчин нөхцөл нь ГШХО-ыг татах гол хүчин зүйл бөгөөд худалдааны өндөр зардал нь ГШХО-д сөргөөр нөлөөлсөн болохыг харуулсан болно. Үнэн хэрэгтээ эх үүсвэр болон хүлээн авагч орнуудын хоорондын олон улсын худалдааны иж бүрэн зардал (тарифыг тооцохгүйгээр)



1%-иар буурсан нь ГШХО дунджаар 0.8%-иар өссөнтэй холбоотой. Хүлээн авагч улсын импортын тариф өндөр байгаа нь ГШХО-ын урсгалд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлжээ. Тиймээс худалдааны зардлыг бууруулах нь чухал юм.

Худалдаа, хөрөнгө оруулалтад нөлөөлж буй дээр дурдсан хүчин зүйлсэд үндэслэн Монгол Улсын Засгийн газарт хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор хөрш орнуудын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд дараах худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхийг АмЧам Монголоос зөвлөж байна. Үүнд:

- Худалдаа, хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Тарифын болон тарифын бус саад тотгорыг арилгах;
- Гадаад худалдааны харилцаанд саад учруулж буй одоогийн хууль тогтоомж, зохицуулалтыг эргэн харах;
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор экспортын баримжаатай бүтээгдэхүүнийг төрөлжүүлж, сурталчлах;
- Органик болон эко бүтээгдэхүүний экспортыг дэмжих;
- АНУ, Европын Холбоо, Япон, Солонгос зэрэг гуравдагч хөрш орнуудаас хамгийн сүүлийн үеийн технологи, бүтэн болон хагас автомажсан тоног төхөөрөмж, машин механизм, байгальд ээлтэй бүтээгдэхүүн импортлоход дэмжлэг үзүүлж, татварын таатай бодлого, гаалийн хурдан шуурхай үйлчлгээ болон нөхцөлөөр хангах.

3.1. Бодлогын шинэчлэлийн гурван тулгуур

Монгол Улс шинэ ГШХО татах, одоогийн гадаадын хөрөнгө оруулагчдыг авч үлдэхийн тулд бизнес, хөрөнгө оруулалтын орчны экосистемийг сайжруулах бодлогын шинэчлэлийн дараах гурван тулгуурыг хэрэгжүүлэх ёстой. Үүнд:

I. Хувийн хэвшлийн бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчид манлайлсан чөлөөт зах зээлийн эдийн засгийг тууштай дэмжин хөгжүүлэх

- а. Төрийн зах зээл дэх оролцоог хумих: үүнд, төрийн өмчит аж ахуйн нэгж ба төлөвлөгөөт эдийн засгийн бодлого, улсын төлөвлөгөөт хөрөнгө оруулалтыг багасгах.
- б. Хувийн хэвшлийн бизнест төрийн оролцоог арилгах (төр зөвхөн бодлого тодорхойлогч үүргийг гүйцэтгэх).
- в. Чөлөөт зах зээл, хувийн хэвшилд тулгуурласан бодлого, хууль тогтоомжийг дэмжих.
- г. Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх: Үүний тулд институцийн хөрөнгө оруулагчид буюу хөрөнгө оруулалтын болон тэтгэврийн сангуудыг үүсгэж, хөгжүүлэх.
- д. Жижиг, дунд үйлдвэрүүдийн эко систем, хөгжлийг дэмжих, тухайлбал бичил санхүүжилтын шинэ эх үүсвэр бий болгох, татварын хөнгөлөлт болон урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх.



II. Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг шинэчлэх

а. Хууль тогтоомжийн гол чиглэлүүдийг шинэчлэх

- i. Нээлттэй зах зээлийг дэмжих хөрөнгө оруулалтын бодлого, эдийн засгийн хөшүүрэг ба дэмжлэг бүхий Хөрөнгө оруулалтын тухай хуулийг боловсруулан батлах.
- ii. Хөдөлмөрийн тухай хуулинд зах зээлийн чиг баримжаатай, гэрээ хийх эрх чөлөө, өрсөлдөх чадвар, өсөлтийг хувийн ашиг сонирголоос илүүгээр дэмжсэн байдлаар нэмэлт өөрчлөлтүүд оруулж, бизнес дэх төрийн оролцоог хязгаарлаж, хөрөнгө оруулалт, ажлын байр бий болгохыг дэмжих.
- iii. Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого, Ашигт малтмалын тухай хуулийг эдийн засгийн үр ашигтай, хөрөнгө оруулалтад чиглэсэн, хувийн хэвшлийн хайгуул, олборлолтод түшиглэсэн болгох.
- iv. Татварын хууль тогтоомжид хөрөнгө оруулалтыг үргээсэн заалтуудыг өөрчлөх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх (жишээ нь WHT буюу хувьцаа шилжүүлсний татварын хэмжээг бууруулах)

б. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хүлээлгүйгээр байнгын идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг Хөрөнгө оруулалтын зөвлөлийг төр, хувийн хэвшил, тухайлбал, худалдааны танхимуудын оролцоотойгоор шинэчлэн зохион байгуулах.

в. Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг шинэчилж, маргааныг шударгаар, үр дүнтэй шийдвэрлэдэг болгох.

г. Татварын маргааныг түргэн шуурхай, үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор Татварын маргаан таслах зөвлөлийг шинэчлэх.

д. Төрийн албыг илүү мэргэшсэн, чадварлаг болгох, иргэн төвтэй төрийн үйлчилгээний соёлд суурилсан төрийн албаны тогтвортой тогтолцоог хөгжүүлэх.

III. АНУ болон гуравдагч хөрш орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүс нутгийн худалдааны интеграцыг нэн тэргүүнд тавих

Монгол улс дараах олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхитэй оролцож, үр шимийг нь хүртэх хэрэгтэй байна. Үүнд:

а. Дэд бүтцийг хөгжүүлэх олон улсын санаачлага (Global Infrastructure Initiative.)

б. Энэтхэг-Номхон далайн эдийн засгийн бодлого (Indo-Pacific Economic Framework).

в. Хоёр талын харилцаа: Ил тод байдлын гэрээний хэрэгжилтийг бүрэн хангах замаар Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлын суурийг тавих шаарддагатай.



1.2 Бодлогын урамшуулал

Монгол Улсын Засгийн газар, УИХ-аас хөрш орнуудтайгаа худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, нэмэгдүүлэх зорилгоор импортын татвар, НӨАТ, онцгой албан татвараас чөлөөлөх бодлогын хөнгөлөлт, татварын хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй.

Эдгээр урамшуулал нь Монгол Улсын төрийн дараах бодлогын зорилтод чиглэгдэж болно. Үүнд:

- Хөгжиж буй хөрш орнуудын сүүлийн үеийн техник, технологи, ноу-хауг нэвтрүүлэх;
- Ажлын байрыг нэмэгдүүлж, орон нутгийн хүний нөөцийн чадавхи, өрсөлдөх чадварыг хөгжүүлэх;
- Урт хугацаанд Засгийн газрын татварын орлогыг нэмэгдүүлэх;
- Зардлыг бууруулах замаар салбар, үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг дээшлүүлэх;
- Нийгэм, байгаль орчны асуудлуудыг шийдвэрлэх.

Хөрөнгө оруулагчдад төрийн бодлогоор дэмжлэг үзүүлэхээс гадна тэд улс төрийн тогтвортой байдал, аюулгүй байдлыг хөрөнгө оруулалтын үндсэн хүчин зүйл гэдгийг Монгол Улсын Засгийн газар анхаарах хэрэгтэй.

